

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр, Лхагва гараг**

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

*Хуралдааны товч тэмдэглэл:* 1-2

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:* 3-4

---

*1.Байнгын хорооны тогтоолын төсөл  
/Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит  
чуулганы 12 дугаар сард Боловсрол, соёл,  
шинжлэх ухаан, спортын байнгын хорооны  
хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/* 3-4

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны  
12 дугаар сарын 13-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Б.Баярсайхан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 19 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Г.Мөнхцэцэг, А.Адъяасүрэн, Т.Аубакир, Л.Энх-Амгалан;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Ганхуяг.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан хэлэлцэх асуудлын дарааллын нэгдүгээр асуудал болох “Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 39 дүгээр тогтоолын 1.5 дахь дэд заалтын хэрэгжилтийг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээллийг Засгийн газрын гишүүн байхгүй байгаатай холбогдуулан дараагийн хуралдаанаар хэлэлцүүлэх горимын санал гаргав.

**Б.Баярсайхан:** Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Баярсайхан тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн асуусан асуултад Байнгын хорооны дарга Б.Баярсайхан хариулж, тайлбар хийв.

**Б.Баярсайхан:** “Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 14 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 07 минут үргэлжилж, ирвэл зохих 16 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр 14 цаг 26 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:

БОЛОВСРОЛ, СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БАЯРСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр,  
Лхагва гараг

Төрийн ордон “Жанжсин Д.Сүхбаатар”  
танхим 14 цаг 19 минут.

### **БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Б.Баярсайхан:** Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаан эхэлснийг мэдэгдэж байна.

Өнөөдөр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос хуралд ирвэл зохих 16 гишүүнээс 9 гишүүн ирсэн байна. Хурлын ирц 56.2 хувьтай байгаа учраас хурлаа эхэллэе.

Хуралд ирсэн гишүүдийг танилцуулъя. Балжиннямын Баярсайхан гишүүн 9 дүгээр тойргоос сонгогдсон, ирсэн. Амгалангийн Адъяасүрэн гишүүн орон нутагт томилолттой ажиллаж байна. Пүрэв-Очирын Анужсин гишүүн ирсэн байна. Тилеуханы Аубакир гишүүн орон нутагт томилолттой ажиллаж байгаа. Энхбаярын Батиугар гишүүн ирсэн байна. Хассуурийн Ганхуяг гишүүн өвчтэй байна. Гонгорын Дамдинням гишүүн ирсэн байна. Бадарчийн Жаргалмаа гишүүн ирсэн байна. Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн орон нутагт томилолттой ажиллаж байна. Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн ирсэн байна. Чинбатын Ундрам гишүүн ирсэн байна. Ням-Осорын Учрал гишүүн ирж байгаа. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн ирсэн байна. Содномын Чинзориг гишүүн ирсэн байна. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн гадаадад томилолттой ажиллаж байна.

Өнөөдрийн хуралдаанаар хоёр асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явцын талаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын мэдээллийг сонсоно.

Мөн бусад гэсэн асуудалд дотор энэ 12 дугаар сард тус Байнгын хороогоор хэлэлцэх хурлын цаглаврыг батлах юм.

Нэгдүгээр асуудал буюу Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явцын талаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын мэдээллийг сонсохоор төлөвлөсөн боловч салбарын сайд байхгүй учраас энэ асуудлыг хойшлууллаа.

Нэгдүгээр асуудлыг салбарын сайдаас ажлын явцын талаар сонсохыг гишүүд санал гаргасан учраас хойшлуулъя гэсэн саналын томъёоллоор санал хураая.

Эхний асуудал дэмжигдлээ.

Хоёр дах асуудал цаглавар батлах асуудал байгаа.

**“Намрын чуулганы 12 дугаар сард Байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоол төслийг хэлэлцье.**

Байнгын хорооны тогтоол төслийг та бүхэнд тараасан байгаа. Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Мөнхцэцэг гишүүн.

**Ц.Мөнхцэцэг:** Манай энэ Улсын Их Хурлын намрын чуулганаар Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн төсөл хэлэлцэгдэнэ гэж яригдаж байсан. Ер нь өргөн баригдсан уу, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн төсөл маань хэзээ орж ирэх юм бол?

**Б.Баярсайхан:** Манай Байнгын хороон дээр хоёр чухал хууль байгаа. Шинжлэх ухаан, инновацын тухай хууль, Шинжлэх ухааны технологийн тухай хууль байгаа. Энэ хоёр хуулийг 12 сардаа багтаан өргөн барихаар яаманд чиглэл өгсөн байгаа. Тэгэхээр энэ хоёр хуулийг энэ парламентын намрын чуулганаар өргөн барьж, хэлэлцэх асуудлыг бас иуурхайлуулан ажиллах болно. Баярлалаа. Үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна.

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Баярлалаа. Өнөөдрийн хуралдаанаар цаглаврыг 70 хувийн саналаар баталлаа.

Өнөөдрийн хуралдаанд хүрэлцэн ирсэн эрхэм гишүүддээ баярлалаа. Хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

14.26 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР